12

БНМАУ-ЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯАМНЫ САЙДЫН ТУШААЛ, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

# ТОГТООЛ

1981 оны 11 р сарын ны 11 өдөр

Дугаар 255/255

Улаанбаатар хот

**ТОЛГОЙТ ДАХЬ ХАЛУУН УСНЫ 2-Р САЛБАРЫГ ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ**

Нефть хангамжийн төв баазын резервуарын паркат ойрхон, уурын зуух салхины дээд талд байрласан нь галын аюул гарсан нөхцөлд резервуарын паркийг бүхэлд нь хамрах аюултай байгаа болон энэ талаар БНМАУ-ын СнЗ-өөс өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор БНМАУ-ын Нийтийн аж ахуй үйлчилгээний яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Толгойт дахь халуун усны 2-р салбарыг 1981 оны 9-р сарын 15-наар тасалбар болгон татан буулгасугай.

2. Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар /н.Мандах/-т үүрэг болгох нь:

а/ Халуун усны захиргааны 1981 оны төлөвлөгөөнөөс халуун усны 2-р салбарын орлого үйлчилгээний төлөвлөгөөг хасахгүйгээр бусад салбаруудаар нь нөхөж биелүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

б/ Халуун усны 2-р салбарын 257,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг халуун усны захиргааны балансаас хасч тооцох;

в/ Халуун усны үйлчлэгч ажилчид 13 хүнийг орон тоо дутуу ажиллаж байгаа халуун усны салбаруудад шилжүүлж тэднийг тодорхой ажлаар хангах;

| | |
|---|---|
| БНМАУ-ЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯАМНЫ САЙД О.НЯМАА | УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ |